



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар Б/51

Хэрлэн сум

Урамшуулал олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2, 1.2.2, 2.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Агентлаг, байгууллагын 2023 оны 3, 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн агентлаг, байгууллагын дарга нарт мөнгөн урамшуулал олгосугай.

2.Урамшуулал олгох агентлаг, байгууллагын дарга нарын нэрсийг хавсралтаар баталсугай.

3.Төрийн жинхэнэ албан хаагчид Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", төрийн үйлчилгээний байгууллагын дарга нарт Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу байгууллагын батлагдсан төсөвтөө багтааж, улирлын ажлын үр дүнг албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хүртэл хувиар тооцож, мөнгөн урамшуулал олгохыг агентлаг, байгууллагын нягтлан бодогч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023  
оны 12 дугаар сарын 19-ны  
6/51 дугаар захирамжийн хавсралт

## УРАМШУУЛАЛ ОЛГОХ АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРЫН НЭРС

№	Нэр	Байгууллагын нэр	Ерөнхийлөн захирагчийн үнэлгээ
1	Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газар	90,2
2	Г.Сэдэдмаа	Статистикийн хэлтэс	98,8
3	Г.Лхагвахатан	Орон нутгийн өмчийн газар	99,5
4	А.Гантөмөр	Татварын хэлтэс	96,57
5	Д.Пүрэвжав	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	99,8
6	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газар	99,4
7	Д.Хатанбаатар	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	96,8
8	Ш.Цолмон	Шүүх, шинжилгээний алба	100
9	Б.Төрхүү	Улсын бүртгэлийн хэлтэс	98,5
10	Э.Хонгорзул	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	97,6
11	Х.Уртнасан	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	92,1
12	Г.Нэргүйбаатар	Биеийн тамир, спортын газар	91
13	Н.Нямхатан	Нийгмийн даатгалын хэлтэс	92,2
14	С.Хэнчмэдэхгүй	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	93,3
15	Т.Зулбаатар	Соёл урлагийн газар	95,7
16	Б.Хэрлэнчимэг	Ус цаг уур, орчин шинжилгээний алба	89,4
17	Э.Жавхлантөгс	Цагдаагийн газар	91
18	С.Мөнхцэцэг	Боловсрол, шинжлэх ухааны газар	94,7
19	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газар	87
20	Ч.Ундармаа	Батширээт сум дундын ойн анги	85,3
21	Г.Даваажаргал	"Биндэр-Ой" сум дундын ойн анги	88,8